

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратегитөлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар /	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ЗОРИЛГО: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна. / “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр”-ийн 3.3.4.4, Өвөрхангай аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 20 дахь заалт. /							
1.1.1	Улсын бүртгэлийн хэлтсийн байр барих газрын асуудлыг шийдвэрлэх.	Улсын болон орон нутгийн төсөв	-Газар авах хүсэлтийг хүргүүлэх; -Кадастрын зураг хийлгүүлэх; -Газрын гэрчилгээг авах; -Санхүүгийн тайланд тусгах.	Тус хэлтэс нь 204 кв хэмжээ бүхий орон нутгийн өмчийн байранд үйл ажиллагаа явуулдаг ба байр архивын болон үйлчилгээ явуулах стандарт хангахгүй байгаа.	Улсын бүртгэлийн хэлтсийн байр барих газартай болсон байна.	Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны 04 сарын 20-ний өдрийн А/208 захирамжаар Арвайхээр сумын 13 дугаар баг, Т.Намнансүрэнгийн 7-р гудамж, 711 тоотын урд 1200 кв газрыг 30 жилийн хугацаатайгаар төрийн байгууллагын зориулалтаар Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлэх захирамж гарч, гэрээ хийгдэж газар эзэмших гэрчилгээг аваад байна.	100%
1.1.2	Бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг үе шаттайгаар	Орон нутгийн төсөв Койка төсөл	Хүлээн авах ажлын хэсэг байгуулах; -Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүлээн авч, акт	Бүртгэлийн анхан шатны нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа сумдын улсын бүртгэгч нарын тоног	2-5 бүртгэгчийн компьютер тоног төхөөрөмжийг шинэчилэн сайжруулсан	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр нийгмийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт 2	60%

	шинэчилэх.	5 сая	үйлдсэн байх; Бүртгэгчид хүлээлгэн өгөх	төхөөрөмжүүд ашиглалтын хугацаа дууссан.	байна.	скайнер /Canon DR-M260/ Хайрхандулаан, Нарийнтээл сумдад Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдоход юнителийн 4G модем 2 ширхэг, улсын төсвөөс Хархорин сумын иргэний бүртгэгчид Канон-3010 маркийн үйлдэлт принтерийг хүлээлгэн өгч үйл ажиллагаандаа хэрэглэж байна.	
1.1.3	Нэгдсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбох	-	Онлайнсүлжээнд холбосон сумдын тоо;	Өвөрхангай аймгийн 16 сум улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон.	Холбогдоогүй нийт 3 сумдыг онлайн сүлжээнд холбосон байна.	Бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон тус аймгийн 16 сум 2020 онд бүрэн холбогдсон байсан, 2021 оны 05 сарын 26- ны өдөр Хайрхандулаан, Нарийнтээл сумд бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдож, сумын бүртгэгчид онлайн сүлжээнд ажиллах эрхийг нээлгэсэн ба иргэний бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг онлайн сүлжээнд бүртгэж, бүх төрлийн лавлагааг сумандаа гарган иргэдэд түргэн шуурхай үйлчилж байна. Бат- Өлзий сум 2017 онд онлайн сүлжээнд холбогдсон боловч ЗДТГ-ын байр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор онлайн сүлжээнд холбогдох боломжгүй байдалтай байна.	95%
1.1.4	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа,	-	Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан тоо;	2020 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 87 засвар	Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн	Тус хэлтсийн болон 19 сумын улсын бүртгэгчдийн бүртгэлийн нэгдсэн онлайн сүлжээ болон тоног төхөөрөмж техник хэрэгслийн ажлын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. 2021 оны 05 сард Нарийнтээл,	95%

	аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах			үйлчилгээг хийсэн.	ажиллагаа хангагдсан байна.	Хайрхандулаан сумдыг УБЕГ-ын Бүртгэлийн нэгдсэн онлайн сүлжээнд холбон ажиллах боломжоор ханган ажиллалаа.	
1.1.5	Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний булан бий болгох	-	Цахим үйлчилгээний булангаар үйлчлүүлсэн үйлчилгээний тоо;	-	Цахим буланг үйл ажиллагаанд хэрэглэж эхэлсэн байна.	Тус хэлтсийн үйлчилгээний зааланд иргэн өөрөө өөртөө үйлчлэх цахим бүртгэлийн булан би болгон шаардлагатай тоног төхөөрөмжийг байрлуулан иргэнд үйлчлэн ажиллаж байна. Тус буланг тохижуулахад 350,000 төгрөгийг батлагдсан төсвөөс зарцуулсан бөгөөд нийт 117 иргэн өөртөө үйлчлэх үйлчилгээнд хамрагдсан.	95%
1.1.6	Үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим машин, төлбөрийн системээр авах нөхцлийг бүрдүүлж, сурталчилан ажиллах	-	-Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо; -Сурталчилсан байдал;	2020 онд И-баримт апп, Киоск цахим төлбөрийн машинаар 38 иргэн үйлчилгээ авсан. Киоск цахим төлбөрийн машин суурилуулахаар ГЭРЭГЭ ХХК-тай гэрээ байгуулсан.	Цахим хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна. Шинээр Киоск цахим төлбөрийн машин үйлчилгээний танхимд суурилуулж үйлчилгээнд нэвтрүүлнэ.	Улсын бүртгэлийн ерөнхий газар болон “Гэрэгэ Систем” ХХК-д Киоск машин худалдан авах төлбөрийн асуудлыг шийдвэрлэх боломж байхгүй байгаа талаар тавьсан хүсэлтийн дагуу дээрх компани “D” киоскыг улсын бүртгэлийн хэлтсийн байранд 1 ширхэгийг үнэгүй тавьж өгөхөөр тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг хийсэн ба суурилуулахад бэлэн болоод байна. Иргэд үйлчилгээний төлбөрөө цахим банк буюу ХААН банкны салбар дээр байршсан Киоск цахим төлбөрийн машин ашиглан 100 хувь үйлчлүүлсэн байна.	70%
ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ							

Зорилт 2. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.

2.2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	-Бүртгэлийн тоо; -Үнэн зөв хөтлөгдсөн эсэх	Өмнөх онд эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр 13244 бүртгэлийг хуулийн хугацаанд бүртгэж баталгаажуулсан байна. Иргэний бүртгэлээр 12086 Хуулийн этгээдийн бүртгэлээр 684 мэдүүлэг хүлээн авч 1097 бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэж эх нотлох баримтыг цахим мэдээллийн санд тухай бүр оруулан ажилласан.	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр 7367 хуулийн хугацаанд бүртгэж баталгаажуулсан. Үүнээс: анхны бүртгэл 256, гэрээний бүртгэл 6137, өөрчлөлтийн бүртгэл 441, лавлагаа 263 байна. Иргэний бүртгэлээр 8093 бүртгэл хийгдсэн байна. Үүнээс: иргэний 8 төрлийн бүртгэл 4163, лавлагаа 2657, шилжилт хөдөлгөөний бүртгэл 1273 байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлээр нийт 340 хүсэлт хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэлийг хөтөлж онлайн системд оруулан баталгаажуулсан байна. Шинээр байгуулагдсан-89, хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт-244, салбар төлөөлөгчийн газрын бүртгэл-1, татан буугдсан-4, оноосон нэрийн хүсэлт-129, тамга тэмдэг хураан авсан-10, эцсийн өмчлөгч нөхөн бүртгэсэн-168, иргэн хуулийн этгээдэд лавлагаа 153 байна. .	100%
2.2.2	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг	-	-Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо;	2020 оны жилийн эцэст гадны аймаг нийслэлийн харьяа 19 салбар төлөөлөгчийн газар бүртгэж гэрчилгээ олгосон.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бүртгэлтэй салбар	Тайлант хугацаанд Хүртээмжтэй хөгжил санаачлага ХЗХ-ны Өвөрхангай салбарын бүртгэлийн хүсэлтийг холбогдох журмын дагуу хүлээн авч бүртгэсэн.	20%

	бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох		-Олгосон гэрчилгээний тоо;		төлөөлөгчийн газрыг урьд оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ.		
2.2.3	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх	-	-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо; -Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо;	2020 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 6241, хууль хяналтын байгууллагад 518 иргэний лавлагаа, мэдээллийг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 166, хууль хяналтын байгууллагад 38 хуулийн этгээдийн лавлагаа, мэдээлэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 703 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар, хууль хяналтын байгууллагад 251 албан бичгээр лавлагаа тус тус олгосон.	Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 263, хууль хяналтын байгууллагад 28 албан тоотойр 108 иргэний лавлагааг хүргүүлсэн. Иргэний улсын бүртгэлээр иргэнд 2386, вэб лавлагаа-11, албаны хэрэгцээнд 57, хууль хяналтын байгууллагад 39 албан тоотойр 106 иргэний лавлагааг тус тус гаргаж хүргүүлсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас тайлангийн хугацаанд иргэнд-142, хууль хяналтын байгууллагад 8 удаа лавлагаа, төрийн байгууллага, албан газарт 3 удаа лавлагаа, мэдээллийг хүргэж ажилласан. Мөн УБЕГ-ын ХЭУБГ-т шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг гаргаж хүргүүлсэн.	100%
2.2.4	Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн	-	-Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч	2020 оны жилийн эцсийн байдлаар 3 хуулийн этгээд татан буугдсан байна.	Улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээдийг байгууллагын	Тайлант хугацаанд тус бүртгэл хийгдээгүй.	-

	байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах		санхүүгийн байгууллагад илгээх; -Баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг хүлээн авах; -Байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлах; -Хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах;		цахим хуудсаар нийтэд зарласан байна. Хуульд заасан хугацааны дараа хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах бүртгэл хөтөлсөн байна.		
2.2.5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангах, судалгааг УБЕГазарт хүргүүлэх;	-	-Хүний нөөцийн судалгаа гаргаж, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах; -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх;	Хархорин сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.	Алслагдсан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна.	Хүний нөөцийн судалгаа гаргаж, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж, 2 улсын бүртгэгчийг нэмж эрх зүйч мэргэжлээр төгссөн. Иргэдэд газар дээр нь түргэн шуурхай үйлчлэх, зардал чирэгдлийг багасгах зорилгоор тогтмол хэрэгжүүлж хэвшсэн эд хөрөнгийн бүртгэлийг анхан шатанд хүлээн авах ажлыг сумдын бүртгэгч нараар дамжуулан авч байгаа бөгөөд жилийн байдлаар Уянга сумаас 25, Төгрөг сумаас 6, Баруунбаян-Улаан сумаас 5, Сант сумаас 5, Есөнзүйл сумаас-6, Хайрхандулаан сумаас 2, Богд сумаас 25, Зүүнбаян-Улаан сумаас 6, Тарагт сумаас 10, Бат-Өлзий сумаас-15, Нарийнтээл сумаас 5, Гучин-Ус сумаас-5 , Баян-	50%

						Өндөр сумаас-1, Баянгол-25, Хужирт-3, Бүрд-5, Өлзийт-4 Хархорин -428 бүртгэлийг тус тус хүлээн авч нийт 716 бүртгэлийг бүртгэж сумдын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн.	
2.2.6	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн хариуцлагын даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	-Гэрээний хэрэгжилтийн хувь;	Хариуцлагын даатгалд хамрагдах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын судалгааг ЭХЭУБГазарт хүргүүлсэн.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулж, гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Хариуцлагын даатгалд хамрагдах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын судалгааг ЭХЭУБГазарт хүргүүлэн 100 хувь бүгд хамрагдаж хариуцлагын даатгалд хамрагдах танилцуулга сургалтанд тасгийн 5 бүртгэгч хамрагдсан.	90%
Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.							
2.3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд төлөвлөгөөт 9, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 3 хяналт шалгалт хийж, 96 дүгнэлт гаргасан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна.	Засгийн газрын 2011 оны 11 сарын 09-ний өдрийн 311 тогтоол “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” –ын дагуу 2021 оны 02 сарын 26-ны өдрийн А/11 тушаалаар хяналт шалгалтын баг байгуулан хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	95%

2.3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчилтэй иргэдийн тоо; -Зөрчлийг арилгасан тоо;	2020 онд мэдээлийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 380 иргэдийн зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т албан бичиг хүргүүлж арилгуулсан.	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн зөрчлийг 100% арилгасан байна.	Сар бүрийн бүртгэл хяналт, шалгалтын тоо мэдээ болон зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ажиллагааны мэдээг тогтмол гарган, Зөрчлийн тухай хуулийн дагуу аймгийн Прокурорын газарт хянан шийдвэрлэсэн зөрчлийн тоо мэдээг хүргүүлэн ажиллаж байна. Иргэний улсын бүртгэлийн 4011, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 153, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 39, нийт 4203 бүртгэл хяналт шалгалт хийснээс иргэний улсын бүртгэлийн 7, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 5, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 41 зөрчил тус тус илэрснийг дүгнэлт гарган шийдвэрлүүлсэн.	95%
2.3.3	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	-	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;	2020 онд нийт 3620 бүртгэлд хяналт шалгалт хийж, 75 зөрчил илрүүлж арилгасан.	Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна.	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр: Тус аймагт 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 09-нийг хүртэлх иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалтыг хийсэн. Уг шалгалтанд тус аймгийн 19 сумын 826 бүртгэл	85%

					<p>хамрагдсанаас иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд давхардаж бүртгэгдсэн 6 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн зөрчлийг илрүүлж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр зөрчлийг арилгасан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн сонгогчийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн нотлох баримтын үнэн зөв, сонгогч шилжин явсан, шилжин ирсний бүртгэлд хууль журмын дагуу бүртгэгдсэн эсэх, сонгуулийн тойргийн хороо хэсгийн хорооны хэсэг оноолт үнэн зөв хийгдсэн зэрэг 1328 бүртгэлд хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй.</p> <p>Тайлант хугацаанд Зүүнбаян-Улаан, Богд сумын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 401 бүртгэлд хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар 3 бүртгэлд зөрчил илэрснийг газар дээр нь арилгуулж ажилласан.</p> <p>Иргэний улсын бүртгэгч Ц.Төмөрсүхийн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх биеийн давхцахгүй өгөгдлийн 2262</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>бүртгэлд хяналт шалгалт хийлээ. Үүнд: иргэний үнэмлэхийн 25,45 насны сунгалт 1052, 16 хүрч шинээр иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан 685, иргэний үнэмлэхийн дахин олголтын бүртгэл 525 хамрагдснаас бүртгэлийн зөрчил илрээгүй.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Анхтуяагийн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 01-ний хүртэлх хугацаанд бүртгэсэн өмчлөх эрх шилжсэн 60 бүртгэл, анхны 26 бүртгэлд хяналт шалгалт хийсэн уг шалгалтаар 1 зөрчил илэрснийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болгож зөрчлийг арилгасан. Улсын бүртгэгч Д.Наранцэцэгийн бүртгэсэн 2021 оны 02 дугаар сарын бүртгэлд хяналт шалгалт хийж, 41 мэдүүлэг буруу боловсруулсныг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр зөрчлийг арилгасан.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн /ePRS/ цахим санд алдаатай цахимжсан 67 хувийн</p>
--	--	--	--	--	--

						<p>хэрэгт засвар өөрчлөлт оруулах дүгнэлтийг үйлдэн баталгаажуулж улсын бүртгэлийн хууль тогтоомжид нийцүүлэн зөрчлийг арилгаж ажилласан болно.</p> <p>Хуулийн этгээдийн бүртгэлд хяналт тавих чиглэлээр: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байнгын болон сар бүрийн түүвэрчилсэн хяналтаар иргэн, хуулийн этгээдэд тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын хуудас дахин олгох, мөн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох бүртгэлд хяналт тавин ажиллаж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт шалгалтаар 30 бүртгэл шалгагдаж зөрчилгүй. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим санд алдаатай цахимжуулагдсан 9 бүртгэлд засвар өөрчлөлт оруулах тухай дүгнэлтийг үйлдэн зөрчлийг арилгасан.</p>	
2.3.4	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо;	2020 онд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 485 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг	Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20 дахь заалтад заасны дагуу Зөрчлийн тухай хуульд заасан холбогдох зөрчлийг үйлдсэн 29	90%

				хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 10.220.000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн		хүнд 620.000 төгрөгийн торгох шийтгэлийн арга хэмжээг авч ажиллалаа.	
2.3.5	Аймгийн хэмжээнд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах	-	Арилгасан зөрчлийн тоо;	-	Иргэний оршин суугаа газрын хаягийн зөрчлийг арилгасан байна.	Тайлант хугацаанд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд давхардан бүртгэгдсэн 6 иргэний зөрчлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгаж зөрчилгүй болгосон. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр иргэн, эд хөрөнгийн хаяг зөрүүтэй 256 мэдүүлгийг хүлээн авч бүртгэн зөрчилгүй болгосон.	90%
Зорилт 4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.							
2.4.1	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах	-	Архивын стандартын хэрэгжилтийн хувь;	2020 онд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт үл хөдлөх хөрөнгийн 11418, газрын 15963, хөдлөх хөрөнгийн 5, газар эзэмших ашиглах эрхийн 2660 бүртгэл байна. Хуулийн этгээдийн 2011 хувийн хэрэг бүртгэл байна.	Архивын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	Хэлтсийн дотоод зохион байгуулалтанд өөрчлөлт оруулан 15 мкв талбай бүхий эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын өрөөг гаргаж засвар үйлчилгээг хийж бэлтгэн ашиглалтанд оруулаад байна. 2021 оны 06 сарын 15-ны өдрийн байдлаар хуулийн этгээдийн 2107 хувийн хэрэг, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 31421 хувийн хэрэг, иргэний улсын бүртгэлийн 123675 хувийн хэрэг байршаад байна.	85%
2.4.2	Иргэн, эд хөрөнгө,	-	-Тоолсон иргэний	2019 онд эд	Хэлтсийн	Иргэн, эд хөрөнгө, хуулийн	40%

	хуулийн этгээдийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллого хийж, баримтыг данс бүртгэлжүүлэх		баримтын тоо; -Тоолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо; -Тоолсон эд хөрөнгийн хувийн тоо;	хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн архивт тооллого хийсэн.	иргэний баримтын архивыг 100% тоолсон байна.	этгээдийн баримтын архивыг тоолох бэлтгэл ажил хангагдаад байна. Газар эзэмших ашиглах эрхийн бүртгэлд тооллого хийсэн ба 3368 бүртгэлд бүртгэлийн хуудсыг хэвлэн хадгаламжийн нэгж үүсгэн архивт хадгалаад байна.	
2.4.3	Байгууллагын ББНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлын зохион байгуулах	-	-Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх; -Устгасан баримт бичгийн тоо;	-	Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.	Хэлтсийн даргын 2021 оны 02 сарын 26-ны өдрийн А/09 тоот тушаалаар ББНШК байгуулагдаж 2021 оны 03 сарын 01-ний өдрийн ББНШАК-ын хуралдаанаар 6 нэр төрлийн 21824 хуудас хувийн хэргийг устгахаар ялгаж 04 сарын 07-ны өдөр архивын нийт 86 хадгаламжийн нэгж буюу 21824 хуудас баримтыг усгаж акт үйлдэн ажилласан. 2020 оны хураалгасан тамга тэмдгийг Өвөрхангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2021 оны 02 сарын 26-ны өдрийн А/10 тоот тушаалаар байгуулагдсан комисс нийт 29 тамга, тэмдгийг жагсаалтаар хүлээн авч тухайн өдрөө устган, баримтжуулж холбогдох журмын дагуу акт үйлдсэн ажилласан.	80%
ГУРАВДУГААР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
3.1	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан	-	-Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийн хувь; -Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн	-	Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөг 100	УБЕГаараас ирүүлсэн Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан ажиллав. Улсын ахлах бүртгэгч, иргэний	100%

	<p>нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, дэд төлөвлөгөө батлах</p>		<p>хувь;</p>		<p>хувь хэрэгжүүлсэн байна.</p>	<p>улсын бүртгэгч нар нь election.mn систем рүү үүссэн эрхийн дагуу нэвтэрч санал авах байрны жагсаалт дээр 19 сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолд заасан Өвөрхангай аймгийн 13 дугаар тойргийн 110 хэсгийн санал авах байрыг шинээр бүртгэж оруулав. Хэсэг оноолт хийгдээгүй санал авах байрны хаяг бүртгэгдээгүй 43 иргэнд хэсэг оноолт хийсэн. Тус системийн Хурлын тогтоол бүртгэх цэсийн Тогтоолын жагсаалтыг тогтоол нэмэх цонхоор 19 сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолыг хавсралтын хамт файл болгон нэмж бүртгэв.</p> <p>Тус аймгийн 13 дугаар тойргийн 110 хэсгийн санал авах байрны жагсаалтыг нэг бүрчилэн дахин тулгалт нягтлав. 19 сумын 110 хэсгийн санал авах байранд оноогдох хаягийг /баг нийлсэн, баг хуваагдсан/ дахин шалгасан. Иргэний улсын бүртгэгчид сумын төвийн сонгуулийн насны иргэдийн нэрсийг жагсаалтаар багийн Засаг дарга нараас авч мэдээллийн санд хаяг, овог нэр, регистрийн дугаарын тулгалтыг хийсэн. Сонгогч шилжих хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын 15-наас эхэлж, 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 00.00 цаг хүртэл явагдсан. Өвөрхангай аймгийн</p>	
--	---	--	--------------	--	---------------------------------	--	--

						19 сумын 110 хэсгийн хороодод сонгогч шилжүүлэг хийгдсэн нийт 1667 сонгогч шилжилтийг хийж лавлагаа хэвлэлээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц бүртгэлийг Өвөрхангай аймагт ямар нэгэн зөрчилгүй, амжилттай зохион байгууллаа.	
3.2	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	-Хууль тогтоомжийн дагуу мэдээ, тайланг үнэн, зөв гаргасан байх; -Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх;	Хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдийг мэдээ, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.	Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга болон аймгийн иргэдийн хурлын дарга, Арвайхээр сумын Засаг дарга болон Арвайхээр сумын Иргэдийн хурлын дарга нарт бүртгэлийн үйлчилгээний талаарх болон хүний нөөцийн талаарх судалгаа танилцуулгыг 3 сарын 5-6-ны өдрүүдэд хүргэн хэлтсийн дарга болон тасгийн дарга нар мэдээлэл өгч ажиллалаа. -Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлсэн. Мөн 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг хугацаанд хүргүүлж нэгтгүүлсэн.	100%
3.3	Гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед ажиллах, цар тахлын эсрэг төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл зардлын батлагдсан төсөв 600,000 мянган төгрөг	Төлөвлөгөө гаргах. Хэрэгжүүлж ажиллах.	-	Төлөвлөгөөний дагуу ажлаа тайлагнаж биелэлтийг хангаж ажилласан байна.	Аймгийн онцгой байдлын газраар гамшгаас хамгаалах болон цар тахлын эсрэг ажиллах төлөвлөгөөг батлуулан нийт 4 удаа 30 хоног Дэлгэрэх дэнжийн пост 2 Дайргийн голын постыг 2 удаа хариуцан постонд хэрэглэх 120000 бараа материал, 300 л буюу 450000	95%

						төгрөгийн өртөг бүхий бензинээр ханган ажилласан. Дээрх үйл ажиллагаанд урсгал санхүүжилтээс 570000 төгрөгийн төсвийг зарцуулаад байна.	
ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 1. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.							
4.1.1	Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	-	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх; -Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;	2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 85.82 хувьтай хэрэгжсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 5, 6 дугаар хавсралтын дагуу 2021 оны 03 сарын 03-ны өдөр гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулан мөрдөж ажиллаж байна.	98%
4.1.2	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2021”–ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	-Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд 11 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувийн биелэлттэй гарсан.	Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Хэлтсийн 2021 оны 02 сарын 16-ны өдөр Хэлтсийн алба хаагчдын сургалтыг 9 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг 45 хувиар хангаж ажиллаж байна.	45%
4.1.3	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан	-	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	Тайлант хугацаанд УБЕГ-аас эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 4 онлайн сургалт, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2 сургалт, хуулийн	80%

	байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах		хаагчийн тоо;			этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1, аймгийн Төрийн албаны зөвлөлөөс 1 онлайн, жендерийн чиглэлээр 1, сонгуулийн холбогдолтой 2 онлайн сургалтанд тус хамрагдсан. Хэлтсийн хэмжээнд “Үндэсний бичиг-2025” хөтөлбөрийн хүрээнд 20 алба хаагч 2 ангид хуваарилагдан нийт 21 цагийн сургалтанд хамрагдаж байна. Угийн бичиг хөтлөх аянд нэгдээр багш М.Үүрцайхын сургалтанд 17 алба хаагч хамрагдаад байна. Үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ сэдэвт цахим сургалтад нийт 4 алба хаагч хамрагдан сертификат авсан.	
Зорилт 2. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.							
4.2.1	Улсын бүртгэлийн хэлтсийн байртай болох ажлыг эхлүүлэх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа байрыг засварлах, орчин нөхцлийг сайжруулах.	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;	-	Төлөвлөгөөт ажил бүрэн хэрэгжсэн байна.	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж хэлтсийн үйлчилгээний заалыг засварлаж, эд хөрөнгийн архивын өрөөг өргөтгөсөн. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга болон бүртгэгч нарын өрөөг 2 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалын тусламжаар засварлаж ажиллах орчин нөхцлийг	25%

						сайжруулсан. Хэлстийн байр шинээр бариулах асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажилласнаар 2022 оны төсөвт 1.5 тэрбум төгрөгийг тусгуулахаар ажиллаж байна. Хэлтсийн хаягийг шинэчилж крилл болон үндэсний бичгээр хослуулан хаягжуулалтыг хийгээд байна.	
4.2.2	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь; -Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байдал;	2020 онд тус хэлтэст нийт 167 өргөдөл гомдол ирснийг шийдвэрлэж хариуг өгсөн. Хугацаа хоцорсон өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна.	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.	Иргэдээс ирсэн хүсэлтийг тухай бүр нь хүлээн авч шийдвэрлэн ажилласан болно. Тайлант хугацаанд 66 өргөдлийг хүлээн авч 47 өргөдлийг шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй 19 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна. Бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор албан хаагчдын нэр дээр ирүүлсэн гомдол, санал байхгүй болно.	
4.2.3	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих	-	-Баримт бичгийн эргэлтийн тоо; -Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь;	2020 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 1746 бичиг ирсэн, үүнээс хариутай албан бичиг 703 байсан. Хариутай албан бичгийг шийдвэрлэлтийн байдал 100 хувьтай.	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна.	Тайлант хугацаа/2021 оны 06 сарын 15-ны өдрийн байдлаар/-нд нийт албан бичиг 796 ирж, 456 албан бичгийг холбогдох газруудад явуулж, албан хэрэг хөтлөлтийн стандарт заавар журмын дагуу бүртгэлжүүлж ажилласан. Ирсэн албан бичгийг дотор нь ангилж үзвэл дээд газраас /Улсын бүртгэлийн ерөнхий	100%

						<p>газар, аймгийн Засаг даргын тамгын газар, хэлтэс албадаас /-244, Хууль хяналтын байгууллагаас-92, бусад хэлтэс, агентлаг, албан байгууллагаас 460 албан бичиг ирсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд хариутай 203 бичиг ирснийг бүртгэлд аван бүртгэл хяналтын карт хөтлөн албан бичгийг хугацаанд нь хүргүүлсэн байна. Тайлангийн хугацаанд хууль хяналтын байгууллагаас 92 албан бичиг ирснээс эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 30, иргэний бүртгэлийн 35, хуулийн этгээдийн бүртгэлээр 8 лавлагаа, эрх түтгэлзүүлэх 8, эрх сэргээсэн 5, бусад 8 албан бичиг гарган хүргүүлэв.</p> <p>Явуулсан албан бичгийг дотор нь ангилж үзвэл дээд шатны байгууллагад /Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Засаг даргын тамгын газар/-192, Хууль хяналтын байгууллагад 118, аймгуудын хэлтэс, бусад агентлаг, албан байгууллага, иргэдэд 146 албан бичгийг стандарт зааврын дагуу боловсруулан бүртгэл хөтлөн ажилласан.</p>	
4.2.4	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; -Ёс зүйн арга	-	Үйл ажиллагаандаа дүрэм, журмыг мөрдөж, стандартын	Улсын бүртгэлийн хөдөлмөрийн дотоод журам шинэчлэлтэй холбоотой саналд хэлтсээс 2 санал хүргүүлснээс 1 санал нь	100%

	стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих		хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;		зөрчил гараагүй байна.	тусгагдан батлагдсан ба дотоод журмыг нийт алба хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулан албажуулсан. Төрийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн талаар сургалтыг бүртгэлийн болон итгэмжлэгдсэн ажилтанд 2021 оны 05 сарын 12-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Үйлчилгээний стандартыг өдөр тутамдаа мөрдөн ажиллах талаар алба хаагчдад сурталчлан энгэрийн тэмдэг, үсний даруулга, бүртгэлийн үйлчилгээний ажилтнуудын болон бүртгэлийн төрөл тус бүрээр стандартад нийцсэн танилцуулга самбар дөрөвийг хийж байршуулсан.	
4.2.5	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулах ажлыг зохион байгуулах	-	Албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн үзлэгт хамруулсан эсэх;	-	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	COVID-19 шалтгаалан хэлтсийн алба хаагчийг 2 шатны вакцинд бүрэн хамруулж иргэдэд үйлчлэх үйлчилгээг 100 хангасан.	100%
4.2.6	Даргын зөвлөлийн болон бүх албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтөлж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Хөтөлсөн хурлын тэмдэглэлийн тоо; -Үүрэг даалгаврын тоо; -Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь;	2020 онд 9 удаагийн даргын зөвлөлийн шуурхай хуралдаан зохион байгуулж, албажуулсан ба нэгжүүдэд 6 үүрэг даалгавар өгөгдсөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй.	Тэмдэглэлийг тухай бүр нь албажуулан хурлаас өгөгдсөн үүрэг, даалгаврууд бүрэн хэрэгжсэн байна.	Тайлант хугацаанд 6 удаагийн хурлын тэмдэглэл хөтлөн тухай бүр албажуулан хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлж ажилласан. УБЕГазраас 18 чиглэл, зөвлөлж ирснийг тус бүрийн хариуцсан тасаг, улсын бүртгэгч, алба хаагч нэг бүрт танилцуулах,	95%

						хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн 19 сумдын улсын бүртгэгч нарт цахимаар танилцуулан ажиллаж байна.	
4.2.7	Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даргын тушаал шийдвэрийг хяналтад авч бүртгэл хөтлөх	-	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой даргын тушаал, шийдвэрийн тоо, хяналтад авсан эсэх;	2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын 56 тушаал, 19 үүрэг даалгавар ирсэн.	Тушаал шийдвэрийн бүртгэлийг сар, өдрийн дарааллаар нарийн хөтөлсөн байна. Хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	2021 оны эхний хагасын байдлаар УБЕГ-ын даргын а тушаал 9, Б тушаал 12 батлагдан ирснийг хяналтандаа авч мөрдөн ажиллаж байна. Хэлтсийн даргын А тушаал 14, Б тушаал 7 батлагдан гарсныг албажуулан мөрдөж байна.	100%
4.2.8	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах	-	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх;	2020 онд Төрийн болон албаны нууцтай холбоотой 1 хариутай албан бичиг ирсэн 1 явуулсан.	Хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж хэлтсийн 46, Монгол улсын Ерөнхийлөнчийн сонгуульд ажиллах 110 итгэмжлэгдсэн ажилтнаас нууцын баталгаа гаргуулан авч ажилласан. Мөн Тагнуулын хэлтсийн алба хаагч ахлах дэслэгч Б.Ууганбаяр “Төрийн болон албаны нууц” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.	100%
4.2.9	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын	2020 онд фэйсбүүк хуудас болон цахим хуудсанд 16 удаа байршуулсан.	Сар бүр мэдээлэл байршуулсан байна.	Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл санхүүгийн мэдээллийн ил тод байдлын мэдээ мэдээллийг тухай бүр болон батлагдсан хуваарийн дагуу сар бүр үзүүлсэн мэдээ мэдээллээр 12 удаагийн график тоон мэдээг байршуулан ажиллаж байна.	90%

			цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;				
4.2.10	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	-Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл; -Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст хүргүүлсэн байдал;	2020 онд 13 хэрэг маргаанд улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон.	Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, байгууллагын эрх ашгийг бүрэн хамгаалсан байна.	Иргэн Д.Туяагийн нэхэмжлэлтэй эцгийн нэр алдаатай бүртгэгдсэн гэх хэрэгт Улсын бүртгэлийн хэлтсийг төлөөлсөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр иргэний улсын бүртгэгч Ц.Төмөрсүх оролцон иргэний бүртгэлийн цахим сан болон Архангай аймгийн УБХэлтсээс гаргасан лавлагааг үндэслэн тайлбар гаргаж зөрчлийг шийдвэрлүүлсэн болно.	100%
4.2.11	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох	-	-Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулсан тоо; -Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо;	2020 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг цахим болон фэйсбүүк хуудсанд 32 удаа байршуулсан. Орон нутгийн телевиз, сонинд 1 удаа мэдээлэл хийсэн.	Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн чанартай хийж хэрэгжүүлж буй ажлын талаар иргэд, олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна.	2021 оны хагас жилийн байдлаар хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг фэйсбүүк хуудсанд 119 мэдээ мэдээлэл, uvurkhangai.burtgel.gov.mn цахим хуудсанд 45 мэдээ мэдээллийг байршуулсан байна.	80%
4.2.12	Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах	-	“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо;	2020 онд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 1 удаа зохион байгуулсан.	Нээлттэй хаалганы өдөрлөгийг 5-с доошгүй удаа зохион байгуулсан байна.	Үүсээд байгаа цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор нээлттэй хаалганы өдөрлөгүүд хойшлогдож 4 дүгээр улиралд хийгдэхээр төлөвлөгдөөд байна.	-
4.2.13	Иргэдийн санал хүсэлтийг сонсох ...	-	-Утсаар лавлагаа мэдээлэл авсан	Хэлтсийн лавлах 70322606 утсанд 26	Улсын бүртгэлийн чиглэлээр иргэдэд	Хэлтсийн лавлах утас болон иргэн, эд хөрөнгө, хуулийн	100%

	утасны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах		тоо;	иргэн утсаар холбогдсон, тухай бүр шийдвэрлэсэн.	үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэсэн байна.	этгээдийн бүртгэлийн талаар холбогдох утсуудыг цахим орчинд байршуулан тухай бүр нь мэдээлэл, зөвлөмжийг хүргэн ажиллаж байна. Лавлах утсаар 158 иргэнд зөвлөгөө өгч ажиллалаа.	
Зорилт 3. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана.							
4.3.1	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах		Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх;	2020 онд төрийн байгууллагуудтай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж, хэлтсийн үйлчилгээний заал засварлах, авто машины асуудлыг шийдвэрлэж 37 сая төгрөгийн дэмжлэг авсан.	Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна.	Бүртгэлийн хэлтсийн үйлчилгээ, хүний нөөц, тулгамдаж буй асуудал зэргийг холбогдох албан тушаалтнуудад танилцуулснаар байгууллагын заалны засвар үйлчилгээнд 7 сая төгрөгийг шийдвэрлүүлж үйлчилгээний заалыг бүрэн засварлуулсан. Хамтран ажилладаг барилгын компаниудын тусламж дэмжлэгээр эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн өрөөг 2 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалын тусламжтайгаар засварлуулсан. Арвайхээр сумын шинэ суурьшилын бүсэд 1200 кв газар эзэмших асуудлыг Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлж 2022 оны төсөвт хэлтсийн шинэ барилгын төсвийн төслийг батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Аймгийн Зооноз өвчин судлалын байгууллагатай	100%

						хамтран цар тахлын үед 3 удаагийн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийгээд байна. Аймгийн Боловсрол, соёлын газартай хамтран “Үндэсний бичиг-2025” аяныг байгууллага дээр эхлүүлээд байна. Тагнуулын хэлтэстэй хамтран ажиллаж нууцын шуудангаар хөнгөлөлтэй үнээр албан бичгийг хүргүүлэн шуудан холбооны зардлыг 20 хувиар хэмнэн ажиллаж байна.	
Зорилт 4. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.							
4.4.1	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах	Батлагдсан төсөв	-Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх; -Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх;	2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч, 2020 онд 580,917,700 сая төгрөгийн урсгал төсвөөс 575,738,935,95 төгрөгийг зарцуулсан.	Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна.	Төсөвт байгууллагын санхүүгийн нэгдсэн тайланг 1 удаа улирлаар, төсвийн гүйцэтгэлийн мэдээг 5 удаа сараар гаргаж, улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүү төлөвлөлтийн газарт хугацаанд нь хүргэсэн байна. Мөн улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан өр төлбөр үүсгэхгүйгээр санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэвчиж болох зардлыг хэмнэн 2,454,909 төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр	50%

						зөрчилгүй дүгнэгдэн 71,9 мянган төгрөгийн зөрчил илэрснийг 1 дүгээр улиралдаа зөрчлийг арилгаж алдааг дахин гаргахгүй байх зорилт тавин ажиллаж байна.	
4.4.2	Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах	-	-Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх; -Үнэт цаас, маягт болон бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх; -Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх;	2020 онд төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй, нээлттэй байдлаар хууль тогтоомжийн дагуу зарцуулсан.	Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна.	2021 оны төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй, нээлттэй байдлаар хууль тогтоомжийн дагуу зарцуулсан. 2021 оны эхний хагас жилийн тооллогоор 239 ширхэг 762,700 төгрөгийн бичиг хэргийн материал 60502 ширхэг 13,723,360.2 төгрөгийн үнэт цаас, 304 ширхэг 256,262,530.61 төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус тоологдлоо. Тооллогоор дутсан илүүдсэн хөрөнгөгүй хагас жилийн байдлаар актлах хөрөнгө байхгүй засвар үйлчилгээ хийх 6 төрлийн тоног төхөөрөмж байна. Төсвийн хүрээний 2 дугаар улиралд дээд шатны байгууллагаас 670,000 төгрөгийн өртөг бүхий 3 үйлдэлт принтер мөн сүүлийн үеийн технологийн дэвшилтэд 2 ширхэг 4,2 сая төгрөгийн өртөг бүхий сканерийн хөрөнгө оруулалт хийгдсэн.	50%
4.4.3	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах	-	-Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо; -Хугацаандаа байршуулсан эсэх;	2020 оны 12 сарын 25-ны байдлаар байршуулах ёстой 135 төрлийн мэдээ байршуулсан	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд онцгой анхаарч хэлтсийн хэмжээнд хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулж тус хугацаанд 60	50%

				99.3 хувиар дүгнэгдсэн.		<p>мэдээ байршуулахаас 60 мэдээ байршуулсан. Хугацаа хоцролттой дутуу байршигдсан мэдээлэл байхгүй хуулийн хэрэгжилт 100 хувьтай байна. Тухай бүрийн мэдээнд санхүүгийн жилийн хүрээнд өссөн дүнгээр 218,431,600 сая төгрөгийн урсгал санхүүжилт гүйлгээ, 118,354,688.90 төгрөгийн үйлчилгээний орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зарлагын гүйлгээ зэргийн хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Хэлтсийн даргын тушаал шийдвэрийг бүрэн байршуулсан. Өмнөх оны аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хуулийн хугацаанд байршуулан аймгийн аудитын газар хүргүүлсэн. Тус онд байгууллагын бүтэц орон тоонд төрийн захиргааны 2 албан хаагч жирэмсэн амаржсаны чөлөө авсан. Бүтэц орон тооны өөрчлөлтийн хөдөлгөөнийг тухай бүрийн мэдээнд тусган ажилласан. Мөн жилийн дүнгээрээ 5 сая төгрөгөөс дээш 8,5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ гарах түлш халаалтын зардлыг шилжүүлдэг “Газрын улаач” ХХКомпанийн мэдээллийг байршуулан ажилласан. Нэг сарын гэрээний дүн 1,715,868 төгрөг болно.</p>	
--	--	--	--	-------------------------	--	---	--

4.4.4	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, тогтмолжуулах	-	<p>-Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах; -Хүчингүй болсон үнэт цаас, тамга тэмдгийг журмын дагууустгах; -Төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогод бэлтгэх; - Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх; -Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сантай болох; -Хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмжийн ашиглалт үзүүлэлтийн судалгаа гаргах; -Тайланг 2 удаа хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах;</p>	Байгууллагын эд хөрөнгийн тооллого, хүчингүй болгосон үнэт цаасны зарцуулалт, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах зэргээр 3 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.	Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна.	Тус онд байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг хэлтсийн даргын 2021 оны 02 сарын 05-ны өдрийн А/07 тушаалаар шинэчлэн байгуулж 2021 онд зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөг батлуусан. Зөвлөлийн гишүүд нь төлөвлөгөөний дагуу 5 дугаар сард Үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор байгууллагын дансанд бүртгэлтэй бүх үндсэн хөрөнгөнд үзлэг шалгалт хийж хэлтсийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын эвдрэл гэмтлийг мэдээлэл технологийн ажилтнаар оношлуулж засвар үйлчилгээг хийлгэн ажиллалаа. Мөн хагас жилийн үндсэн хөрөнгө, бараа материалыг тооллогыг зохион байгуулж илүүдсэн дутагдсан хөрөнгө байхгүй болно	50%
Зорилт 5. Хэлтсийн хэмжээнд шинэлэг ажлыг санаачлан төлөвлөж, хэрэгжүүлнэ.							
4.5.1	Улирал бүр шинэлэг ажил санаачлан хэрэгжүүлнэ.	Багаж техник хэрэгсэл, 1,092,000 Урсгал засварын зардлын батлагдсан	-Байгууллагын өнгө үзэмж сайжруулах, ажиллагсдын хувцсыг жигдлэх, -Монгол бичиг-2025 -Угийн бичиг	-	Улирал бүр нэг шинэлэг ажлыг зохион байгуулсан байна.	Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулан нийт 20 алба хаагчдын дүрэмт хувцсыг жигдлэн үйлчилгээний стандартыг хангасан. “Монгол бичиг-2025” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Боловсрол, соёл, урлагийн газартай	90%

		төсөв 390,000 мянган төгрөг	хөтлөх -Байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг чиглэлээр шинэлэг ажлуудыг зохион байгуулна.			<p>хамтран тус хэлтсийн 20 алба хаагчийг түвшин тогтоон 2 анги болгон 21 цагийн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Угийн бичиг хөтлөх сарын аянд нэгдэн Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн багш М.Үүрцайхаар 2 цагийн сургалтыг зохион байгуулан хэлсийн 1 алба хаагчдыг хамруулан угийн бичгийг хэрхэн хөтлөх вэ?, угийн бичгийн ач тусын талаар тодорхой ойлголттой болсон. Байгууллагын өнгө үзэмжийг орон нутгаас 7 сая төгрөг шийдүүлж, засвар үйлчилгээ хийсэн. Үйлчилгээний танилцуулга салбар шинээр хийж байршуулсан. Байгууллагын хаягжуулалтыг хос бичгээр стандартад нийцсэн загвараар хийлээ.</p>	
--	--	--------------------------------------	--	--	--	--	--

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга

(албан тушаал)

Тэмдэг

..... /Д.Дэлгэрсайхан/

(гарын үсэг)

(огноо)

.....

Төлөвлөгөө тайлагнасан :

Төсвийн Шууд захирагч

Улсын бүртгэлийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)

Тэмдэг

..... /Б.Цэдмаа /

(гарын үсэг)

(огноо)

.....